

## ХОВД АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.04.04

Ховд

Тус Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үг, Монгол Улсын Их хурлаас батлан гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны болон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүд, албан даалгавар, тогтоол, Хууль зүй дотоод хэргийн сайдын өгсөн үүрэг, Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандарт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн актуудыг алба хаагчдаар судлуулах, тайлбарлан таниулах, бие бүрэлдэхүүнийг шинэ мэдээ мэдээлэлээр ханган тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх асуудлыг оновчтой шийдвэрлэх чадварыг бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллав.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

А. Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэг, зөрчлийг илрүүлэх ажилд төр захиргаа, иргэд олон нийтийн туслалцаа дэмжлэгийг авах, тэднийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, иргэдийн үнэтэй зөвлөгөө, санал санаачлагыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилдаа тусган хэрэгжүүлэх, тэдний өмнө тулгамдаж байгаа, шийдвэрлэгдээгүй асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, айх аюулгүй амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нартай болон айл өрхөөр биечлэн орж санал хүсэлтийг сонсон ажиллаж байгаа зэрэг ажлыг хийж хэрэгжүүлээд байна.

Цагдаагийн Ерөнхий Газраас 2018 онд дэвшүүлсэн зорилт, Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний заалт, 2017 онд хэрэгжүүлсэн ажлын ололттой ба дутагдалтай зүйлд дүгнэлт хийж, ажлын төлөвлөгөөнд тусган алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагатай холбоотой ажлын чиглэл, шүүх, прокурорын байгууллагын шийдвэр зэргийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллалаа.

Нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээллийг сар бүр аймгийн хууль эрх зүйн хэлтэс, Засаг даргад хүргүүлж, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх шийдвэр гаргуулан хамтран ажиллаж байна.

Хууль зүй дотоод хэргийн сайдын дэмжлэгтэйгээр байгуулагдсан “Теле камерын хяналтын нэгдсэн төв”-ийг ашиглалтанд оруулж Ховд аймгийн төвд 10 байршил 30 чиглэлд телекамерыг байрлуулсан байна.

Цагдаагийн газрын даргын тушаалаар аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ, судалгаанд дүгнэлт хийх, тэдгээрийг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг судлан цаашид авах арга хэмжээг боловсруулан, аймаг орон нутгийн

удирдлагуудад хүргүүлэн шийдвэрлүүлэх зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх судалгааны баг”-ийг байгуулсан.

Судалгааны багаас 7 хоног бүр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг бүрэлдэхүүнд танилцуулж, цаашид ажиллах арга барил, хүн хүчийг тооцоолон ажиллаж байгаа нь тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил буурах, гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулан, олж тогтооход ихээхэн нөлөөлж байна.

Хэлтэс, тасаг, алба хаагчдын үйл ажиллагаагч уялдуулж хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудын хамтаар зохион явуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаа ба Монгол улсад үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн мэдээлэл, аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын байдалд тулгуурлан, үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтыг бууруулах, зорилгоор хууль хяналтын байгууллагаас санал авч, 2018 онд аймгийн хэмжээнд баримтлах нэгдсэн төлөвлөгөөг гаргасан.

Цагдаагийн байгууллагаас тодорхой төрлийн гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулахын тулд иргэд, аж ахуйн нэгжээс үйлдэгдэж байгаа зөрчилд холбогдох хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авч мөнгөн торгууль ногдуулснаас түүний 40 хүртэл хувийг тухайн орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах талаар орон нутгийн төр захиргааны байгууллагад уламжилж тодорхой шийдвэр гаргуулан ажилласан.

Энэ хугацаанд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 6.578.000 төгрөгийг зарцуулсан.

Цагдаагийн газрын болон тасгийн дарга нараас иргэдийг ямар нэг цагийн хязгаар хувиаргүйгээр хүлээн авч, төв конторт “Угтах үйлчилгээ”-г нэвтрүүлж, гомдол, хүсэлт гарган ирж байгаа иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Иргэний журмаар шүүхэд шийдвэрлэх, болон харьяалалын бус асуудлыг хэрхэн хаана очиж шийдвэрлүүлэх талаар жижүүрийн шуурхай албаны хариуцлагатай зохицуулагч, дуудлага мэдээлэл хүлээн авагч, конторын дэг журам сахиулагч цагдаа нар иргэдэд тайлбарлан таниулах, зөвлөх байдлаар ажиллаж байгаад иргэдийн талархалтай хандаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймаг дахь Цагдаагийн газраас 2017 онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ЦЕГ-ын нэгдсэн сүлжээ, Цагдаагийн газрын болон орон нутгийн цахим хуудсанд байршуулж, Ховд аймгийн 16 сум, төвийн 12 багийн 1789 иргэнд тавьж хэлэлцүүлэн, санал хүсэлтийг сонссон.

2018 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг 2018 оны 04 дүгээр сарын 10-ны дотор цахим сүлжээнд байршуулах болно.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, иргэдээс гаргасан санал хүсэлтийг хүлээн авч, хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагаа болон эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, мэдээллийг цахим сүлжээнд байршуулан, орон нутгийн телевизээр 5 удаа нэвтрүүлж, олон нийтэд хүргэсэн.

Энэ хугацаанд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагаанд түшиглэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх, амгалан тайван үйл ажиллагаа явуулах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх шалтгаан нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйг сурталчлан таниулах, хүний эрх эрх чөлөөг хангах зорилгоор Ховд их

сургууль, Политехник коллежийн захиргаа, аймгийн Өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг бууруулах, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйг сурталчлан таниулах зорилгоор Цагдаагийн газрын хэлтэс, тасаг хамтран нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг сард 3-аас доошгүй удаа зохион явуулж тухай бүрд нь илтгэх хуудсаар танилцуулж ажилласан.

Энэ хугацаанд удирдамж төлөвлөгөөний дагуу “Зэвсэг-2018”, “Хөдөөгийн зам”, “Шинэ жил”, “Цаган сар”, “Илрүүлэлт шийдвэрлэлт”, “Хамгаалах бүс”, “Хөдөлгөөний аюулгүй байдал”, “РС тоглоом”, “Тамхины хяналт”, “Шийдвэрлэлт-2018”, “Ломбард” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг төрийн боло төрийн бус байгууллагуудтай хамтран 12 удаа зохион явуулсан.

Цагдаагийн газрын алба хаагчид нийгмийн хариуцлагаа ухамсарлан Хот тохижилт үйлчилгээний ажилчдад халуун чацаргана, аарцаар үйлчилж, “Сайн жолооч”, “Сэтгэлийн бэлэг”, “Хөдөлгөөнд зөв соёлтой оролцъё” зэрэг арга хэмжээнүүдийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион явуулж тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

Б. Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, хүний нөөцийн чиглэлээр:

Тус цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлыг 4 удаа хуралдуулж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 16, хүний нөөцийн чиглэлээр 19 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тус Цагдаагийн газарт Хэрэг бүртгэх албаны мөрдөгчийн орон тоог 2, Булган сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэст 1-ээр нэмэгдүүлэх шаардлагатай байгааг шийдвэрлүүлэхээр Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар, Хэрэг бүртгэх албанд саналыг хүргүүлсэн.

Алба хаагчдын талаарх мэдээллийг цахим санд бүрэн оруулж, ахлагч бүрэлдэхүүний хувийн хэрэгт сарын ажлын үр дүнгээр цалин нэмсэн болон хассан, сахилгын шийтгэл оногдуулсан, ажлын байр өөрчилсөн, удаан жилийн нэмэгдэл олгосон, шагнал урамшилд тодорхойлогдсон, шагнагдсан, сургууль, дамжаа төгссөн, нөөцөд авагдсан зэрэг мэдээллийн баяжилтыг хийж хэвшсэн ба ахлагч бүрэлдэхүүнийг хувийн хэрэгтэй нь танилцуулах баяжилт хийх зорилгоор “Хувийн хэргийн баяжилт” нэртэй ажил арга хэмжээг зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагад анх орж ажиллахаар хүсэлтээ гаргасан иргэдийг судлах, шалгаруулах, томилох, албан тушаалд дэвшүүлэхдээ Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх” журмыг мөрдөн шинээр ахлагчийн бүрэлдэхүүнд 2 алба хаагчийг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан “Албан тушаал дэвшүүлэх” журам /код 909/-ын 909.7-д заасны дагуу тус газрын 4 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн, 1 алба хаагчийн цолыг сэргээж Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчөөр, 1 алба хаагчийг офицерын бүрэлдэхүүнд оруулж, хэсгийн байцаагчаар тус тус томилуулсан.

Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж хэвшсэн.

В. Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Тус цагдаагийн газрын хэлтэс, тасгийн дарга нар 7 хоногоор ажлаа төлөвлөж, хийсэн ажлын тайланг тасгууд хуваарийн дагуу бүрэлдэхүүнд танилцуулж, удирдлагаас өгсөн ажлын чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг тооцон цаашид хийх ажлаа төлөвлөж хэвшсэн.

Цагдаагийн газрын даргаас хэлтэс, тасгийн дарга, алба хаагч нарт ажил

сайжруулах үүрэг, зааварчлага 8-г бичиж, биелэлт үр дүнг тооцсон.

Мөн хугацаанд Цагдаагийн газрын даргаас хэлтэс, тасгийн дарга нар болон алба хаагчдад бүртгэлээр 85 үүргийг өгч биелэлт үр дүнг тухай бүрт нь тооцсон байна.

Өгсөн үүргийг хэрэгжүүлээгүй, биелүүлээгүй алба хаагч байхгүй байна.

Алба хаагч бүртэй тасгийн дарга нар үр дүнгийн гэрээ байгуулсан.

Алба хаагчдын ажлыг сар бүр дүгнэж, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн цалинг үр дүнгээр олгож хэвшсэн.

Алба хаагчдыг цалингийн болон орон сууцны хөнгөлттэй зээлэнд хамруулах зорилгоор арилжааны банкуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, алба хаагчдыг зээлд хамруулаад байна.

Байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан бусад орон нутгаас тус цагдаагийн газарт томилогдон ажиллаж байгаа 3 алба хаагчийг орон байраар ханган, алба хаагчдыг ая, тухтай нөхцөлд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор 27 алба хаагчийн өрөө тасалгааг засаж, тохижуулсан.

Гэрийн гишүүдийн харилцаа холбоог сайжруулах, тэдэнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, санал сэтгэгдлийг нь сонсох зорилгоор алба хаагчдын гэр бүлийг хүлээн авч уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Уулзалтын үеэр алба хаагчдаас урлагийн тоглолт үзүүлж, Ховд их сургуулийн багш нар “Гэр бүлийн аз жаргал”, “Гэр бүлийн хоорондын харилцаа” сэдвээр сургалт орсон.

Сар шинийн баярыг тохиолдуулан Цагдаагийн газраас цэргийн байнгын тэтгэвэрт гарсан Ховд аймагт амьдарч байгаа 26 ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, санал хүсэлтийг сонсож, гарын бэлэг гардуулсан.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Бүсийн оношлогоо, эмчилгээний төвтэй хамтран зохион байгуулахаар гэрээ байгуулав.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдыг артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэлтэд үнэ төлбөргүй хамруулах ажлын бэлтгэлийг хангаад байна.

Г.Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл,  
гомдол шийдвэрлэлтийн талаар:

Энэ оны 1 дүгээр улиралд Цагдаагийн газрын удирдлагад иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон алба хаагчдаас 42 өргөдөл гомдол ирүүлснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Эдгээрийн 13 нь ажилд орох, 7 нь шилжин ажиллах, 5 нь захиргааны чөлөө хүссэн, 17 нь орон сууц, тэтгэвэр, тэтгэмж хүссэн байна.

Мөн Цагдаагийн газрын үйл ажиллагаа болон цагдаагийн алба хаагчтай холбоотой 4 мэдээлэл ирүүлснийг тухай бүрт нь албаны шалгалтыг явуулж шийдвэрлэн, хариуг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнд мэдэгдэж ажиллав.

Д.Судалгаа, дүн шинжилгээ хийсэн  
ажлын талаар:

Энэ оны 1 дүгээр улиралд тус Цагдаагийн газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 841 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.5 хувиар буурсан байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 104 нь гэмт хэргийн шинжтэй, 737 нь зөрчлийн шинжтэй гомдол мэлээлэл бүртгэгджээ.

2018 оны 1 дүгээр улиралд 87 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 31.5 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 21.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 28.4 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 23 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 45.2, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 17 бүртгэгдсэн нь 56.4 хувь, хулгайлах гэмт хэрэг 21 бүртгэгдсэн нь 58.5 хувь, үүнээс хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 19 бүртгэгдсэн нь 38.7 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 8 бүртгэгдсэн нь 60.0 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь 33.3 хувиар тус тус буурч, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 3 дахин, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 39 бүртгэгдсэн нь 37.0 хувь, залилах гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 3 дахин, хөрөнгө завших гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 50.0 хувь, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 100 хувиар тус тус өсчээ.

Согуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 23 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 28.1 хувиар буурч, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 8 бүртгэгдсэн нь 33.3 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь 25.0 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 3.5 дахин өсч, 38 хүн гэмтсэн нь 26.9 хувиар буурсан.

Зөрчлийн шинжтэй 737 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 172 буюу 18,9 хувиар буурсан байна.

Хүлээн авсан зөрчлийг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл 85 буюу 11,5 хувийг зөрчлийн хэрэг үүсгэж, 453 буюу 61,5 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 194 буюу 26,3 хувийг зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 5 буюу 0,7 хувийг харьяалалын дагуу шилжүүлж шийдвэрлэжээ.

Ховд аймгийн хэмжээнд 2018 оны 03 сард 2553 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2334 буюу 47,8 хувиар, зөрчил гаргасан 2379 иргэнийг 152,010,300 төгрөгөөр торгож, 118 жолоочийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 56 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан 670 зөрчил бүртгэгдсэнээс 572 буюу 85,4 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 98 буюу 14,6 хувийг зөрчлийн хэргийн үүсгэн шалгасан байна.

Албадан саатуулах байранд 411 хүн эрүүлжүүлэгдсэнээс 18 буюу 4,4 хувийг эмэгтэй, 3 буюу 0,7 хувийг 18 хүртлэх насны хүүхэд эзэлж байна.

Е.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйг сурталчлан таниулах чиглэлээр:

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эрүүгийн хэрэг, материалыг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор аймгийн Прокурорын газартай хамтран 3 удаагийн, захиргааны хяналтанд байгаа этгээдүүдийг нийгэмшүүлэх, тэднийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран 1 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Ховд Орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж, Жаргалант сумын Засаг дарга, Тамгын дарга, Жаргалант сумын 12 багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн

эрүүл мэндийн ажилтан, хэсгийн байцаагчид, иргэний төлөөлөл, нийт 59 иргэнийг хамруулсан.

Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүх, аймгийн Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх нээлттэй, хаалттай хорих 457 дугаар ангитай хамтран, Хууль сахиулах байгууллагуудын зөвлөгөөнийг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн гишүүдээс санал авч, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Тухайлбал: “Хуулиа мөрдье-21”, “Сэрэмжилье нэгдье”, “Хуулийн хэрэгжилт” аян, нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж, архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн эрхлэгч, ажилчдыг оролцуулан холбогдох байгууллагуудын хамтаар “Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлье” сургалт зөвлөгөөнийг зохион явуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Мөн аяны хүрээнд орон байрны хулгай болон архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 18 төрлийн шторк, контентыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, архины хор хөнөөлийг харуулсан шторк, санамж, зөвлөмж, гарын авлага материал хэвлүүлэхэд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 1.000.000 төгрөг, аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Тайван амгалан Ховдчууд” хөтөлбөрийн санхүүжилтээс 4.478.000 төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажилласан.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн зөвлөлийн салбар зөвлөлд санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ажлын төлөвлөгөө, зардал, төсвийг хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, санал асуулга авч, түүний мөрөөр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах, хууль, эрх зүйн мэдээлэл түгээх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион явагдаж буй “Хуулийн-Хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд салбар төлөвлөгөө гарган, ерөнхий боловсролын 23 сургууль, Ховд их сургууль, Политехник коллеж зэрэг төрийн болон төрийн бус 46 байгууллага, аж ахуйн нэгжид “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-иудаар сургалт зохион байгуулж, 2500 гаруй иргэнийг хамрууллаа.

Мөн нэгдсэн арга хэмжээний хүрээнд Булган, Алтай, Үенч сумдад ажиллаж, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 9 төрлийн шторк, контентыг орон нутгийн телевизээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар 80 удаа иргэд, олон нийтэд хүргэсэн.

Мал хулгайлах болон зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Шүүх, Прокурорын газартай хамтран сумдад бүсчилсэн сургалт, зөвлөгөөнийг 5 удаа 900 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

Нууц далд аргаар үйлдэгдсэн эдийн засгийн болон мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг тус цагдаагийн газарт 3 алба хаагч хариуцан ажиллаж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн талаар авагдсан мэдээллээр 1-р улиралд 5 хэрэг илрүүлж ажилласан. Цагдаагийн газраас Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүргийн

хүрээнд нутаг дэвсгэрийн хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглэгчийн цар хүрээ, сэжигтэй байр байгууламж, цаашдын чиг хандлагыг тодорхойлох чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын 12 сургууль, Ховд их сургууль, Политехник коллеж, Боловсрол соёлын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар, эцэг эхчүүдийн төлөөлөлтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ховд аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2012 оны 03-р сарын 16-ны өдрийн 26 тоот тушаалын хавсралтаар 25 эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, аж ахуйн нэгжүүд сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилж байна. Ховд аймгийн хэмжээнд Хогийн олсны ургамал буюу Каннабисын тархацтай Алтай сумын Алтангадас баг, Булган сумын Бүрэнхайрхан багийн Булган голын сав газар, Үенч сумын Хөх үзүүр багийн төв зэрэг газруудад хяналт тавьж 2018 оны 06-р сарын 15-ны өдрөөс 2018 оны 06-р сарын 20-ны өдрийн хооронд Каннабисын тархацыг тогтоох, устгах ажлын төлөвлөгөө гаргасан.

Аймгийн бүсийн оношлогоо эмчилгээний төвийн сэтгэц наркологиин тасагтай хамтран мансууруулах эм сэтгэцэт нөлөөт бодисыг эмчийн хяналтан дор хэрэглэдэг, эмнэлэгийн байнгын болон түр хяналтанд байдаг сэтгэцийн эмгэгтэй 271 иргэний судалгааг гаргаж, Мэргэжлийн хяналтын газрын чиглэл хариуцсан байцаагчтай хамтран мэдээлэл солилцон, хяналт тавин ажиллаж байна. Энэ оны 03-р сарын 25-ны байдлаар мансууруулах эм сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглэгчийн цар хүрээ, сэжигтэй байр байгууламжийн талаар мэдээлэл авагдаж, энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй.

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн зурагт хуудас бүхий 6 төрлийн материалыг интернэт үйлчилгээ үзүүлж байгаа кафенууд, 12 жилийн болон их дээд сургуулиуд хүн олноор цуглардаг банк, үйлчилгээний байгууллагуудад тараан байршуулж ажилласан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нартай хамтран архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдэд үзлэг шалгалт хийж, 650 ширхэг санамж, зөвлөмж тараан өгч, 26 нэр төрлийн 484.000 төгрөгийн хугацаа дууссан пиво, хүнсний зүйлийг хураан авч устгалд оруулан, 3 хүнийг холбогдох хуулийн дагуу 350.000 төгрөгөөр торгож, яриа таниулга хийж ажилласан ба 8 төрлийн 8000 ширхэг санамж, зөвлөмж, уриалгыг иргэд олон нийтэд тараан өгөх санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын Ховд аймаг дахь Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төрийн бус байгууллагатай хамтран Жаргалант сумын 12 багийн Засаг дарга, сургуулийн болон багийн нийгмийн ажилтан, 5 сумдын хэсгийн төлөөлөгч нарыг оролцуулан хамтарсан багийн үйл ажиллагааг хэрхэн эрчимжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээг цогц байдлаар хэрхэн хүргэх талаар сургалтыг 2 удаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэглэх ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээллийн шийдвэрлэлтэнд анхаарах чиглэлээр Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч, Хэсгийн байцаагч нарт чиглэлээр 3 удаа сургалтыг тус тус зохион байгуулсан.

Цагдаагийн газрын үйл ажиллагаа болон эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, мэдээллийг цахим сүлжээнд байршуулан, орон нутгийн телевизээр 5 удаа нэвтрүүлж, олон нийтэд хүргэсэн.

Хууль зүй дотоод хэргийн сайдын багцаас санхүүжүүлсэн “Теле камерын хяналтын нэгдсэн төв” нь замын хөдөлгөөнд оролцох явцдаа хамгаалах бүс зүүгээгүй, гар утсаар ярьсан, уулзвар гарцаар эгнээ байр буруу эзэлж эргэсэн 36, таксигаар

үйлчлүүлэх явцдаа эд зүйл, гар утас зэргээ мартаж буусан 13 иргэний хүсэлтээр тээврийн хэрэгслийг олж тогтоон ажиллаад байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас хүний эрхийн комисстой байгуулсан “Санамж бичиг” хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Д.Бямбадорж 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Цагдаагийн газрын үйл ажиллагаа болон Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаатай биечлэн танилцсан бөгөөд гэмт хэрэгт сэрдэгдсэн, эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан этгээдүүдэд үйлчлэх үйлчилгээг жигд хэвийн явуулж, хүний эрхийг хамгаалах, Эрүүлжүүлэх байрны алба хаагчдын эрүүл, аюулгүй, ая тухтай нөхцлийг бүрдүүлэх, байрны үйл ажиллагаа ахуй нөхцлийг сайжруулах чиглэлээр зөвлөгөө өгч, алба хаагчдын санал хүсэлтийг сонссон. Тус үйл ажиллагаатай танилцах үеэр ямар нэгэн зөрчил дутагдал заагдаагүй.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

А. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Эрүүгийн цагдаагийн тасаг нь 2018 оны 01 дүгээр улиралд Эрүүгийн цагдаагийн албанаас 93 албан бичиг хүлээн авч 72 албан бичигт заасан үүрэг, даалгавар ажлын чиглэл, саналуудыг гаргаж холбогдох алба, газар хэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн байгууллагын “Asap” санд эрэн сурвалжилж байгаа оргодол байхгүй бөгөөд гэмт хэрэгт сэрдэгдсэн 4 этгээдийг эрэн сурвалжлан олж тогтоосон.

Энэ хугацаанд 19 холбогдогчтой 193.110.000 төгрөгний хохиролтой 21 хэргийг илрүүлж, мөрдөн байцаах тасагт шилжүүлэн, 14 хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хаах саналтай аймгийн Прокурорын газарт хүргүүлж, харьяаллын дагуу 2 хэргийг бусад цагдаагийн байгууллагад, 3 хэргийг шүүхэд шилжүүлсэн ба одоо ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 90 хэрэгт ажиллагаа хийж байна.

Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргүүдийн болон хэргийн газраас алдагдсан мал, эд зүйлсийн содон шинж тэмдгийн талаар алба хаагчдад танилцуулж, эрэн сурвалжлах ажлыг тасралтгүй зохион байгуулав.

Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн алба бусад газар хэлтсээс ирүүлсэн удирдамжийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эзэнгүй хэргийг илрүүлэх чиглэлээр “Шийдвэрлэлт-2018” “Ломбард” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Мөн Монгол улсын ерөнхий прокурорын А/57 дугаар тушаалаар батлагдсан “Мэдүүлэг авах өрөө”-нд тавигдах шаардлагад нийцүүлэн уулзалт мэдүүлгийн 2 өрөөг тохижуулан үйл ажиллагаа явуулж байна.

Жижүүрийн офицер, дуудлага хүлээн авагч цагдаа нар гэмт хэрэг зөрчлийн шинжтэй 219 дуудлага мэдээлэл хүлээн авч цагдаагийн байгууллагын нэгдсэн санд бүртгэж, цохолтын дагуу холбогдох алба хаагч нарт танилцуулан материалыг хүлээлгэн өгч ажилласан.

Б. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Мөрдөн байцаах тасаг гэмт хэргийн шинжтэй 65 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 18 буюу 27,6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай, 10 буюу 15,3 хувьд нь хэрэг бүртгэлтийн дугаар авч, 34 буюу 52.3 хувийг мөрдөн байцаалтын хэрэг нээж, нийт шалгасан гомдол мэдээллийн 22 буюу 95,4 хувийг шийдвэрлэн одоо 3 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалтын дугаартай 63 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсанаас 46 буюу 73,01 хувийг яллах дүгнэлтээр буюу шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж, 5 буюу 7,9 хувийг нэгтгэж, 7 буюу 11,1 хувийг



харъяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн. Нийт шалгасан хэргийн 58 буюу 92,0 хувийг шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлтийн дугаартай нийт 31 хэрэгт ажиллагаа явуулсанаас 5 буюу 16.2 хувийг мөрдөн байцаалтын дугаар авч шийдвэрлэж, 9 буюу нийт шалгасан хэргийн 29,0 хувийг хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 2 буюу 6.4 хувийг харъяаллын дагуу шилжүүлж, 15 буюу 48,3 хувийн хэргийн үлдэгдэлтэй байна. Нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 51,7 хувийг шийдвэрлэсэн бөгөөд гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан 36,9 сая төгрөгний хохиролоос 12,3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

В.Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Хэрэг бүртгэх тасаг нь Мөрдөн байцаах тасагт шалгаж байсан Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан 1 гомдол, мэдээлэл, 4 гэмт хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулан, иргэд, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 14 гомдол, мэдээлэл хүлээн авч, 9 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, 1 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 4 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 10 хэргийг шүүхэд шилжүүлж шийдвэрлэн, 2 хэргийг ажиллагаанд шалгаж байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид учирсан 17.480.0 төгрөгийн хохирлоос 14.780.0 төгрөг буюу 84.5 хувийг нөхөн төлүүлж, 5.350.0 төгрөгний эд хөрөнгийг битүүмжилсэн.

Г. Замын цагдаагийн албаны чиглэлээр:

Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд гудамж, замын хяналтаар 21 алба хаагч 10584 цаг үүрэг гүйцэтгэж, 2194 зөрчил илрүүлсэн.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэсэгсэл жолоодсон 122 жолоочийг илрүүлж, жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтуугаар автомашин жолоодсон 39 жолоочийг Ховд аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, Зөрчлийн тухай хуулийн дагуу газар дээр нь шийдвэрлэх боломжгүй 244 тээврийн хэрэгслийг түр саатуулах байранд саатуулан, Policereader Сат багажаар 2033, шийтгэврээр 45 иргэнд нийт 105.957.750 төгрөгний торгууль ногдуулсан.

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны 102 дугаарын утсанд иргэдээс ирүүлсэн зам тээврийн ослын 61 гомдол, мэдээллийг хүлээн авч, 54 гомдол мэдээллийг захиргааны зөрчлөөр хянан шийдвэрлэж, 7 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэн шалгасан.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх хот хоорондын болон улсын чанартай авто замын хяналтыг сайжруулах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах зорилгоор 7 байгууллага, аж ахуйн нэгж, 2 сумын 1978 хүнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн мэдлэгийг олгох, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадалыг хэвшүүлэх зорилгоор тус аймгийн баруун 5 сум, төвийн 7 сургуулийн бага ангийн сурагчдын дунд “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнийг зохион байгуулсан.

Д. Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

Аймгийн 2017 оны эрүү, хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан, алба хаагчдаас гаргасан саналд тулгуурлан, эргүүлийн чиглэлийг оновчтой зохион байгуулах зорилгоор 2018 оны эргүүлийн нэгдсэн байршилтыг боловсруулж, эргүүлийг өдөр, оройн цагийн хуваарийн дагуу явган болон автомашинтайгаар зохион байгуулан ажиллуулж байна.

Иргэд, байгууллагаас зөрчлийн талаар ирүүлсэн 473 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 51 зөрчлийн хэрэг нээж, 227 гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, зөрчил гаргасан 263 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн дагуу 21.380.000 төгрөгөөр торгож, 21 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар шүүхээр баривчлуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд нарын айлчлал, “Мөнгөлөг шагшуурга” арга хэмжээний үеийн замын хөдөлгөөний болон хэв журмын хамгаалалт, зохицуулалтыг батлагдсан зураглал, төлөвлөгөөний дагуу зөрчил, дутагдалгүй зохион байгуулан ажиллалаа.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдаас иргэний хэргийн 259, эрүүгийн хэргийн 178 шүүх хурлын хамгаалалтанд үүрэг гүйцэтгэн, цагдан хорих байрнаас шүүхэд 4 удаа 11 шүүгдэгчийг, шүүхээс цагдан хорих байранд 15 удаа 25 шүүгдэгчийг хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулж, шүүгчийн захирамжийн дагуу 3 иргэнийг олж тогтоон шүүхэд хүргүүлсэн.

Эрүүлжүүлэх байранд 421, баривчлах байранд 69, нийт 490 иргэнийг хүлээн авч үйлчилсэнээс 5 иргэнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэн, 3 иргэнийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвд хүргүүлж, 42 иргэнийг асран хамгаалах хүнд нь тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгсөн.

Саатуулах байранд хүргэгдэн ирсэн иргэнийг хүлээн авахдаа хүргэж ирсэн алба хаагчийн үзлэгийн тэмдэглэлтэй тулган, хоёроос доошгүй иргэнийг хөндлөнгийн гэрчээр байлцуулан бие, хувцас, эд зүйлд үзлэг хийж хэвшүүлээд байна.

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтанд нийт 15 мэдэгдэл хүргүүлж, 14 мэдэгдлийн хариуг авч, мэдэгдлийн мөрөөр зохион байгуулсан ажлыг газар дээр нь шалгаж ажилласан. Түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 48 удаа нэвтрүүлж, яриа таниулгыг нэвтрүүлж, 4892 хүн, 113 аж ахуй нэгж байгууллагын хамруулан яриа таниулга хийж, 4 сая 500 мянган төгрөгний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан.

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 64, хорих ял эдлээд хугацаанаас өмнө суллагдсан 4, нийт 68 этгээдэд захиргааны хяналт тавьж, хугацаа дууссан үндэслэлээр 5 хэргийг хааж шийдвэрлэсэн.

Е. Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Өмнөх буюу 2017 оны 1 дүгээр улиралын байдлаар насанд хүрээгүй хүмүүсээс 4 хэрэгт 4 хүүхэд холбогдон шалгагдсан ба 2018 оны 1 улирлын байдлаар насанд хүрээгүй хүүхэд холбогдон шалгагдсан гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй болон согтууруулах ундаа хэрэглэн гэр орондоо агсам тавьж, амгалан тайван байдал алдагдуулсан 47 дуудлага мэдээлэл хүлээн авч, жижүүрийн бүрэлдэхүүн, нутаг дэвсгэр хариуцсан хэсгийн байцаагчийг оролцуулан, гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг нийгмийн ажилтантай хамтран тогтоож, хохирогчид сэтгэл зүйн болон хуулийн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх, төрөл садангийн хамгаалалтанд өгөх ажлыг зохион байгуулсан.

Энэ хугацаанд иргэний эрсдлийн үнэлгээг гаргаж, гэр орондоо агсам согтуу тавьсан 18 хүнийг сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногоор баривчлуулж, 5 хүнд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэглэх чадвар эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй захиргааны болон гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн шийдвэрлэлтэнд анхаарах, хамтарсан баг дахь үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч, Хэсгийн байцаагч нарт 3 удаа сургалт зохион байгуулсан.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд баривчлагдсан 18 этгээдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэл”-ээр өдөрт 2 цагийн албадан сургалтыг Гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч, Хүний эрхийн үндэсний комиссын ахлах шинжээчтэй хамтран 45 удаа зохион байгуулав.

Захиргааны хяналтанд байгаа насанд хүрээгүй 1 этгээдэд хяналт тогтоож, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүмүүст “Амьдрах ухааны сургалт”-ыг 4 удаа зохион байгуулсан.

“Түр хамгаалах байр”-д 3 камер суурилуулж, гэр бүлийн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг 47 хүнд үзүүлж, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй зөрчил, хэрэгт “Аюулын зэргийн үнэлгээ”-г тухай бүр тогтоолгов.

Ё. Дотоодын цэргийн тусгай салааны үйл ажиллагааны чиглэлээр:

Тус салаа нь Улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулан үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоог амралт, ачааллыг нь тохируулан ажиллав.

Тусгай салаанаас хоногийн хугацаанд аймгийн төвийн “Шим-Ус” ОНӨААТҮГ-ын объектын шалган нэвтрүүлэх нэгдүгээр цэг, гүний худгийн хоёрдугаар цэгт тус бүр харуулчин 2-ыг 8x16 цагаар, харуулын дарга 1-ийг 24 цагаар, “Дөргөний усан цахилгаан станц”-ын хамгаалалтад харуулын дарга 1, харуулчин 6 нийт 7 алба хаагчийг 7 хоногийн хугацаатай, шалган нэвтрүүлэх гуравдугаар цэг, хяналтын дөрөвдүгээр цэгт тус бүр харуулчин 1, харуулын дарга 1-ийг 24 цагаар тус тус томилон, хүн нэг бүрийг тусгай хэрэгсэл, гав, резинэн бороохой, ПМ маркийн гар буу болон хийн гар буу, хамгаалах хантааз зэргээр хангаж, тусгайлсан үүрэг, чиглэл өгөхөөс бусад үед хамгаалалтыг ердийн цагийн байдлаар зохион байгуулан ажилласан.

Энэ хугацаанд Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/11 дугаартай тушаалаар 2018 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 08.00 цагаас 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 08.00 цаг хүртэл Улсын онц чухал объектын хамгаалалтыг хүч нэмэгдүүлэн зохион байгуулж, салааны алба хаагчид өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэгт шилжин ажилласан.

Холбоо харилцааг суурин болон гар радио станц, дотуур холбоо АТС утас ашиглан мэдээ мэдээллийн шуурхай байдлыг бүрэн ханган тогтоосон цагуудад холбогдох албан тушаалтанд дамжуулан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд “Улсын онц чухал объект”-оор:

- Байнгын үнэмлэхээр нэвтэрсэн иргэн-626
- Гаднаас нэвтэрсэн иргэд-115
- Гадаадын иргэн- 0
- Тээврийн хэрэгсэл-131

- Хяналтанд авсан хөдөлгөөн-854 нийт 1726 хөдөлгөөн шалган нэвтрүүлж ажилласан.

Харуулын 3, 4 дүгээр цэгээр нийт 4 тн ачаа, 1250 толгой бог, 300 толгой бод мал нэвтрүүлж дамжин өнгөрүүлж хяналт тавьж ажилласан.

“Дөргөний усан цахилгаан станц”-ын хамгаалалтад үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг долоо хоног бүр байрлал дээр нь ээлж хүлээлцүүлэн холбогдох үүрэг чиглэлээр ханган хяналт тавьж ажилласан.

2018 оны 1 дүгээр улиралд Улаанбаатар хотоос Завхан аймгийн Дөрвөлжин сумын чиглэлд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж явсан 5 тээврийн хэрэгслийг тус тус хамгаалалтанд авч тус аймгийн нутгаар дамжин өнгөрүүлж аюулгүй байдлыг нь ханган ажилласан.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

А. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн:

Цагдаагийн Ерөнхий газрын дэд даргаас ирүүлсэн 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 4/823 дугаар албан бичгийн дагуу Цагдаагийн газрын алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тэдний санал бодлыг сонсох зорилго бүхий хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 48 офицер, 62 цагдаа оролцсон. Хэлэлцүүлэгтэй холбогдуулан тасгийн дарга 1, ахлах офицер 1, офицер 1, ахлагч бүрэлдэхүүн 1 нийт 4 алба хаагч цагдаагийн алба хаагчийн ёс зүй, ажлын хариуцлага, сахилгыг төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл бэлтгэн танилцуулсан. Мөн алба хаагчид ЦЕГ-аас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, Цагдаагийн байгууллагын алсын хараа, эрхэм зорилгын хүрээнд үнэт зүйлийг дээдлэн албандаа итгэл үнэмшилтэй, албаны бахархалыг хүндэтгэн ажиллах, ёс зүйг төлөвшүүлэх талаар өөрсдийн санаа бодол, хүсэлтээ илэрхийлсэн.

Түүнчлэн 1-р улирлын сахилга хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулав. Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар 28 алба хаагчдад сахилгын шийтгэл оногдуулснаас офицер 26, ахлагч 2, байгаагаас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 14, Цагдаагийн газрын даргын тушаалаар 14 алба хаагч тус тус сахилгын шийтгэл хүлээжээ.

Алба хаагчдын хүсэлтээр нийт бүрэлдэхүүн үйл ажиллагааны журам, ажил үйлчилгээний стандартыг баримтлан, цагдаагийн алба хаагчийн ёс зүйг сахин, хариуцсан ажлаа хуулийн хүрээнд шударгаар биелүүлэхээ баталж, зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай болон Цагдаагийн албаны тухай хууль бусад дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээхээ илэрхийлж бичгээр баталгаа гаргасан.

Тайлангийн хугацаанд сахилгын 20 зөрчилд 28 алба хаагч сахилгын арга хэмжээ тооцогдон, гэмт хэрэгт холбогдсон 2 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар албанаас халагдсан.

Алба хаагчдаас гаргасан сахилгын зөрчлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17 нэгж буюу 65.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, сахилгын зөрчил гаргасан алба хаагчдаар хамт олны өмнө амлалт авахуулж, итгэл хүлээлгэсэн.

Иргэд байгууллага, аж ахуйн нэгжээс цагдаа, дотоодын цэргийн алба хаагчтай холбоотой 4 гомдол ирүүлснийг бүртгэлд авч, холбогдох алба хаагчдад албаны шалгалт явуулан, даргын зөвлөлийн хурлаар оруулан шийдвэрлэж, тухайн иргэнд хариу хүргүүлсэн.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчид нь Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний 13,7 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй

харьцуулахад 17 буюу 65.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Засгийн газрын “Сахилга хариуцлагыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх, “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийг эрчимжүүлж ажиллах хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн Цагдаагийн газрын сэтгэл зүйч алба хаагч нэг бүртэй уулзан тэдний сэтгэл зүйн хэв шинжийг тогтоох зорилгоор хувийн хэрэг нээн ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын даргын тушаалаар Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх орон тооны бус ажлын хэсгийг байгуулан, хууль тогтоомжийг сурталчлах, байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, авлига хүнд суртлыг арилгах, авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн газрын [khovd.police.gov.mn](http://khovd.police.gov.mn) цахим хаяг, “Ховд аймаг дахь Цагдаагийн газар фейсбүүк” цахим сайтуудад авлигын эсрэг хууль тогтоомжийн тухай мэдээлэл болон алба хаагчдаас авлига хээл хахууль, хүнд суртал, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг цахимаар болон бичгээр авах талаар мэдээллийг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтэстэй хамтран, алба хаагчдын дунд сургалт зохион байгууллаа.

Б. Сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурор, шүүхийн мэдэгдэл, шаардлагын талаар:

Энэ оны 1-р улирлын байдлаар аймгийн Прокурорын газраас түдгэлзүүлсэн хэрэгт хийгдэх ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, гэмт хэрэг илрүүлэх ажилд ахиц гаргаагүй гэх зөрчилд шаардлага ирсэний дагуу албаны шалгалт явуулж, зөрчил гаргасан нь нотлогдсон 6 алба хаагчид Цагдаагийн газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан байна. Прокурорын шаардлагад нэр заагдсан алба хаагчдаас дахин зөрчил, дутагдал гаргахгүй ажиллах талаар баталгаа гаргуулан авч, аймгийн Прокурор, Шүүхийн байгууллагатай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж, мөрдөгч нарыг бүрэн хамруулж ажилласан.

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

В. Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:

Улсын их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах шинээр батлагдсан болон, өөрчлөлт орсон хууль тогтоомж, эрх зүйн акт, шинэ мэдээ, мэдээллийг нийт алба хаагчдад танилцуулж хэвшсэн.

“Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 онд явуулах албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийн дагуу Цагдаагийн газрын 2018-2019 онд хэрэгжүүлэх албаны сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж, 01 дүгээр улиралд хэрэгжүүлэх 6 бүлэг 31 заалт бүхий төлөвлөгөө гаргаж, “Авлигын эсрэг хууль тогтоомж, авлигаас урьдчилан сэргийлэх нь”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагын оролцоо”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах нь”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаарх ойлголт”, “Тамхины хяналтын тухай хуулийн талаарх ойлголт”, “Цагдаагийн албаны тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Дотоод аюулгүй байдлыг хангах /Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-113/”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх зарим асуудал”, “Байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх аргачлал”, “Компьютерт вирусын программ суулгах, update татах”, “Албан хэрэг

хөтлөлтийн стандарт”, “ASAP санд нэвтрэх, ашиглах” гэсэн 15 сэдвээр сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 270 алба хаагчийг хамруулж, сургалтын чанар, үр дүнд удирдлагын зүгээс хяналт тавин, сургалт зохиох алба хаагчдад урьдчилан мэдэгдэж, бэлтгэл ажлыг хангуулан сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулахад анхаарч байна.

Долоо хоног бүрийн Даваа, Баасан гарагуудад албаны сургалтыг явуулж хэвшсэн бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу чиглэл тус бүрээр зохион байгуулагдах сургалтанд алба хаагчдыг өргөнөөр хамруулах бодлого барин, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан сургалтанд 10 алба хаагчийг хамруулсан.

Сургалтанд хамрагдсан алба хаагчид сэдвийн дагуу бүрэлдэхүүнд хуваарийн дагуу сургалт орж, материалыг нэгтгэн, Цагдаагийн газрын даргад танилцуулснаар албан томилолтыг олгохоор шийдвэрлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хүний нөөц, сургалтын чиглэлийн цахим сургалтанд Цагдаагийн газрын 25 алба хаагч хамрагдсан.

Мөн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Ёс суртахуун төлөвшил”-ийн сургалтанд 9 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн газрын алба хаагчдаас одоогийн байдлаар Хууль сахиулахын их сургуулийн эчнээ ангид 3 алба хаагч суралцаж байна.

Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад, дотоодын их дээд сургууль, академи болон бусад байгууллагуудад мэргэшил дээшлүүлэх, боловсролын зэргийн урт, богино хугацааны сургалтанд алба хаагчдыг суралцуулах сонгон шалгаруулалт зарлагдсан тохиолдолд мэдээллийг алба хаагчдад шуурхай хүргэж, шалгуур үзүүлэлтийг хангасан алба хаагчийн судалгаа, материалыг холбогдох газарт хүргүүлж байх чиглэлийг хэрэгжүүлэн албаны сургалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэн, сургалтыг шинэ арга барилаар зохион явуулах талаар анхааран ажиллаж байна.

Г.Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:

Хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, алба хаагчид, тэдний гэр бүлийнхний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг хөгжүүлэх, зорилгоордоорх ажил арга хэмжээг зохион байгуулаад байна.

Үүнд: Энэ оны 1 дүгээр сард "Эрүүл агаар-идэвхтэй хөдөлгөөн" сэдэвт цасны баяр арга хэмжээг зохион явууллаа.

Энэ үеэр алба хаагчид, тэдний гэр бүлийнхний дунд олс таталт, цасны сумо, шагайн харваа, хөл бөмбөг, чарганы тэмцээнийг зохион явуулж, тэргүүлсэн баг, хамт олон, алба хаагчдыг шагнаж урамшуулав.

Түүнчлэн соён гэгээрүүлэх ажлын хуваарийн дагуу хэлтэс, тасгаас алба хаагчдын дунд хөл бөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар зэрэг спортын төрлөөр, “Марш тактик” тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээн, Сар шинийн баярыг угтан “32 цагаан лонх тоолох”, “Сээр хугалах”, “Ардын өв уламжлалыг хэн сайн мэдэх вэ” зэрэг уралдааныг тус тус зохион байгууллаа.

Тус аймаг дахь төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагддаг спортын олон төрөлт тэмцээнүүдэд цагдаагийн газрын баг тамирчид амжилттай оролцож, нийлбэр дүнгээр хоёрдугаар байр эзэлсэн.

Мөн баруун бүсийн хэмжээнд зохион байгуулсан “Мөсний баяр-2018” арга хэмжээний үеэр зохион байгуулсан урианхай сур, тэшүүр, олс таталт, өв уламжлалаараа гоёцгооё, цасны сумо зэрэг уралдаан тэмцээнд Цагдаагийн газрын алба хаагчид болон тэдний гэр бүлийнхэн амжилттай оролцсон.

Түүнчлэн цэргийн болон цэрэгжсэн байгууллагуудын бүсгүйчүүдийн дунд жил бүр бүр зохион байгуулагддаг “Мөрдөстэй бүсгүйчүүд” тэмцээнд 8 алба хаагч оролцон дэд байр эзэлсэн.

Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөх, алба хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, илтгэх ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Харилцааны ёс зүй” сэдэвт илтгэлийн уралдааныг зарлан дүгнэсэн.

Алба хаагчдын харилцаа, ёс зүйг төлөвшүүлэх, гоо зүйн мэдрэмж олгох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохиох сургалтын талаарх мэдээллийг Хүний нөөц, сургалтын хэлтсийн Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэст хүргүүлж “Театр урлаг, гоо зүй зан төлөвшилд нөлөөлөх нь”, “Харилцаа-гэр бүлийн аз жаргал” сэдвээр 2 удаа 125 алба хаагчийг хамруулсан сургалт явагдсан.

Түүнчлэн аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн Олон улсын Ховд хөгжлийн хөтөлбөрийн газар, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хамтарсан багийг чадавхижуулах” сургалтанд 6 хэсгийн байцаагч хамрагдсан.

Мөн Ховд аймаг дахь Хувь хүний хөгжлийн институтын захирал Г.Гантогоог урьж “Ухаалаг харилцаа” сэдвээр, Ховд их сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны их сургуулийн багш Н.Бадамцэцэгээр “Гэр бүлийн аз жаргал” “Гэр бүлийн харилцаа” сэдвээр тус тус лекц уншуулж, алба хаагчид сонирхсон асуултаа асууж харилцан ярилцав.

Дөрөв. Санхүү бүртгэл, хангамжийн үйлчилгээний талаар:

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн алба, орон нутгийн санхүүгийн байгууллагаас өгсөн чиглэл, үүргийг хэрэгжүүлэн 2,580,674,900 төгрөгийн батлагдсан төсөвтэйгээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын санхүүгийн аюулгүй байдлыг хангах, төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, түүнийг зориулалтын бусаар зарцуулах, ашиглах, завших, үрэгдүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр орон тооны бус ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд Цагдаагийн газрын дарга биечлэн хяналт тавьж, Цагдаагийн газрын даргын тушаалаар эд хөрөнгийн тооллогыг хийж байна.

Ховд аймгийн Аудитын газраас хийсэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн шалгалтаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй болно.

2018 оны нэгдүгээр улиралд төсвийн урсгал санхүүжилт 637.387.200 төгрөг хүлээн авч батлагдсан төсвийн хуваарь, хүсэлт баталгааны зардлын зүйлийн дагуу 643.059.660 төгрөг зарцуулж тухай бүр гүйцэтгэлийн тайлан гаргасан бөгөөд 2018 оны эхний 3 сарын байдлаар 17.024.838 төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлж, гүйцэтгэлийг сар бүр гаргасан.

Аймаг орон нутгийн төсөв хүү, торгуулийн орлогоор 2018 оны эхний 3 сарын байдлаар 7.470.500 төгрөгийг төвлөрүүлж, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 236.000 төгрөгний үнэт цаас, шийтгэлийн тогтоол хүлээн авч сар бүр тайлан гаргаж хүргүүлсэн.

Үндэсний аюулгүй байдлын болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд байгууллагууд чөлөөтэй харах нөхцлийг бүрдүүлж, 2018 онд нэгдүгээр улиралд 5 саяаас дээш орлогын 7 гүйлгээ буюу 648.370.806 төгрөг, зарлагын 7 гүйлгээ буюу 55.068.894 төгрөгийн мэдээ мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.khovd.police.gov.mn](http://www.khovd.police.gov.mn) сайтуудад болон байгууллага доторхи ил тод байдлын самбар дээр жилийн төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тогтмол байршуулж хэвшсэн.

Тав. Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2018 онд хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын А/12 дугаар тушаалаар байгуулж, орон тооны бус ажлын хэсэг 2018 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний талаар 1 удаа хуралдаж, төлөвлөгөөний биелэлт, явц байдлыг дүгнэсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Дотоод аюулгүй байдлыг хангах” /код-113/, “Байгууллагын нууц тогтоох, хамгаалах” /код-115/-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Дотоод аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалт зохион байгуулсан.

Гал, гамшиг ослын үед алба хаагчийг аврах, объектоос түргэн хугацаанд гаргах зорилгоор авралтын зам, гарцын схем зургийг стандартын дагуу шинэчлэн 3 цэгт байршуулж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх самбар 1, гал унтраагуурын байршил заасан тэмдэг 3, гэрэлтдэг гарцын тэмдэг 3, өндөр хүчдэлийн тэмдэг 1, хонх 1 ширхэгийг шаардлагатай цэгүүдэд байршуулсан.

Дүгнэлт:

Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 37 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 8 буюу 21.6 хувийг нөхөн илрүүлж, яллагдагчаар татаж шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнг урьд оны мөн үетэй харьцуулахад залилах гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 3 дахин, хөрөнгө завших гэмт хэрэг 1 хэргээр буюу 50 хувиар тус тус өсчээ.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 19 хэргээр буюу 45.2 хувиар, хулагайлах гэмт хэрэг 30 хэргээр буюу 30 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 12 хэргээр буюу 60 хувиар нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 хэргээр буюу 50 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5 хэргээр буюу 33,3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/135 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн газрын бүтэц орон тооны талаар Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хоёрдугаар хуралдаанаар хэлэлцээд батлагдсан орон тоондоо багтаан төсөвт нөлөөлүүлэхгүйгээр зарим ажлын байр /албан тушаал/-ыг өөрчлүүлэх саналыг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн бөгөөд дээрх өөрчлөлтүүд нь алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, ажлын байр, ажил үүргийн хуваарь тодорхой болж ажлын үр дүнд эерэгээр нөлөөлнө гэж үзсэн болно.

Алба хаагчдын гаргаж байгаа зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг судлахад дараахь нөхцөл байдлууд тогтоогдож байна. Үүнд:

-Тасгийн дарга, ахлах байцаагч нараас алба хаагчдад тавих хяналт, шаардлага сул

-Хичээл сургалт болон бусад хэлбэрээр сахилга ёс зүй, харилцааны соёлын талаар зааж зөвлөж байгаа боловч үр дүн тооцдоггүй.

-Ёс журам сахиулах эргүүлийн үүрэг гүйцэтгэл хангалттай биш, ёс төдий үүрэг гүйцэтгэдэг.



- Алба хаагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэггүй.
- Офицер алба хаагчдын манлайлал суларсан.
- Хувь хүний ухамсар, ёс зүй төлөвшөөгүй зэрэг шалтгаан нөхцлүүд байна.

Цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж, цагдаагийн алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйг дээшлүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах.

3. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдсан хуулийг алба хаагчдаар судлуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор албаны сургалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэн, сургалтыг шинэ арга барилаар зохион явуулах, мэргэшүүлэх болон давтан сургалтанд хамруулах.

4. Алба хаагчдын гаргасан шинэлэг санал, санаачлагыг дэмжиж, хамт олны эвсэг уур амьсгалыг бэхжүүлэх.

5. Төсөв санхүүгийн байдлаас шалтгаалан эрүүлжүүлэх саатуулах байрны яаралтай тусламжийн эм тариа, эмнэлгийн багаж хэрэгсэлийн хангалт хийгдэхгүй дутуу байгаа тул хоёрдугаар улиралд эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх эм тариа нийлүүлэх.

6. Цагдаагийн газрын зарим ажлын байр /албан тушаал/-ыг баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан төсөвт нөлөөлүүлэхгүйгээр өөрчлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.ГАНБОЛД